

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2020 ОНЫ 5 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, сумд болон Засаг даргын харьяа хэлтэс, агентлагийн дарга нарт 6 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан. Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 06-ны Сүмбэр сум нь "Монгол Улсын Тэргүүний сум"-аар шалгарсан. "Монгол Улсын Тэргүүний сум"-ын шагнал гардуулах арга хэмжээ 5 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулагдсан бөгөөд Сүмбэр сум нь Монгол Улсын Тэргүүний 21 дэх сум болж байна.

Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн сүлжээний хуудсанд нийт 52 удаагийн мэдээллийг нийтэлсэн. Үүнд: Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлт, Хог хаягдлын асуудал, цаг агаарын онц аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлэх, Улсын тэргүүний Сүмбэр сумын шагнал гардуулах үйл ажиллагаа, Элсэлтийн ерөнхий шалгалтын мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор 5 удаагийн шууд мэдээллийг нийгмийн сүлжээгээр цацсан бөгөөд давхардсан тоогоор нийт 29800 иргэнд хүргэсэн.

Оросын холбооны улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхэт Элчин сайд Искандер Кубарович Азизов, Монгол улсаас Оросын Холбооны улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхэт Элчин сайд асан Л.Хангай, Улаанбаатар Төмөр зам ХНН-ийн 1 дүгээр орлогч дарга Игорь Васильевич Мелостных нар 5 дугаар сарын 20-ны өдөр айлчиллаа. Айлчлалын үеэр аймаг орон нутгийн удирдлагууд, Говьсүмбэр аймгийн Монгол, Оросын найрамдлын нийгэмлэгийн гишүүдтэй уулзалт хийж, Орос цэргийн алдрын хөшөөнд хүндэтгэл үзүүлж, цогцолборын тохижилт, бүтээн байгуулалтын ажилтай танилцлаа. Тус арга хэмжээний үеээр Говьсүмбэр аймгийн иргэдээ төлөөлөн аймгийн Засаг дарга Г.Батсуурь ОХУ-ын иргэдэд 5000 ширхэг амны хаалт /mask/, 5 ширхэг зайнаас халуун хэмжигчийг тус тус хандив болгон гардууллаа.

Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолын хүрээнд улсын хэмжээнд 270 суманд "Үйлчилгээний нэгдсэн төв" байгуулагдаж, иргэдэд операторын үйлчилгээг үзүүлэхээр болсон. Энэхүү ажлын хүрээнд 2020 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас төрийн үйлчилгээний нэгдсэн системийг хөгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, аймгийн Засаг даргын Тамгын газар, Баянтал, Шивээговь, Сүмбэр сумын Тамгын газрын 15 албан хаагч хамрагдсан.

Төрийн жинхэнэ албаны тусгай шалгалтыг 2020 оны 5 дугаар сарын 22-ны өдөр зохион байгууллаа. Тус шалгалтанд Орон нутгийн өмчийн газрын дарга, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Захиргаа, хяналтын хэлтсийн дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа, аж ахуйн албаны дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний албаны дарга, Хүнс, хөдөө, аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга, Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын газрын удирдлагын хэлтсийн дарга, Мал эмнэлэгийн газрын Мал эмнэлэгийн тасаг, мал эмнэлэгийн үйлчилгээний нэгж болон дотоод хяналт, шилжилт хөдөлгөөн баталгаажуулалт, эмийн хяналт хариуцсан улсын ахлах байцаагч гэсэн 8 албан тушаалын сул орон тоог нөхөхөөр сонгон шалгаруулалт зохион байгуулснаас, 5 ажлын байр нөхөгдлөө.

2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөс 5 дугаар сарын 2-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд цэргийн жинхэнэ алба хаагаагүй 18-25 насны залуучуудыг цэрэг татлагын товчоон дээр ирүүлэн хугацаат цэргийн албанд татах ажлыг зохион байгууллаа. Цэрэг татлагын товчоо, эмч нарын комисс сумдад ажиллахдаа коронавируст халдвараас урьдчилан

сэргийлж, нэг дор 5-аас дээш цэрэгт татагдагч иргэн цуглуулахгүй байх төлөвлөлт, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн цэргийн албанд татагдагч иргэдэд гар ариутгагч, амны хаалт /mask/-г тогтмол хэрэглүүлж, эрүүл ахуй, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг чанд сахиулан ажиллаж, Зэвсэгт хүчний жанжин штабаас өгсөн тоон даалгаврыг 100 хувь биелүүлсэн.

Коронавируст (covid-19) халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр “Амны хаалт-Бидний аюулгүйн баталгаа” аяныг зохион байгууллаа. Тус аяны хүрээнд Онцгой байдлын газар, Цагдаагийн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорих 425 дугаар ангитай хамтран “Ковид-19” халдвараас сэргийлэх, болзошгүй эрсдлээс сэргийлж амны хаалтаа зүүх эрүүл ахуйн зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэх, иргэдэд холбогдох хуулийг сурталчлах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлэг, мэдээллийг Сүмбэр сумын 1, 2, 3 дугаар багийн иргэдэд тусгай зориулалтын авто машины болон зөөврийн чанга яригчаар хүргэж, 150 ширхэг гарын авлага тараасан.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2020 оны 5 дугаар сарын Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 2096744.0 мян.төгрөг төвлөрүүлэхээс, 2346729.0 мян.төг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 119.9 хувьтай байна.

Улсын төвлөрсөн төсөвт 343300.0 мян.төг төвлөрүүлэхээс 346214.0 мян.төг төвлөрүүлж гүйцэтгэл 100.8 хувьтай байна.

2020 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар татвар төлөгч ХК-1, ХХК-303, ББН-5, ЗБН-10, Хоршоо-27 ОНӨҮГ-6, Салбар-70, Хадгаламж зээлийн хоршоо-1, Төсөвт байгууллага-57, ТББ-90, Шашны байгууллага-5, Сан-10, ОНБ-16 бүртгэгдэн нийт хуулийн этгээд 602 болж 0.5 хувиар нэмэгдсэн байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудад 3692510.9 мянган төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 3677230.0 мянган төгрөг, ОНХСанд 157675,0 мянган төгрөгийн зарцуулалтын эрх төсвийн хуваарийн дагуу бүрэн нээгдэж төрийн сангийн гүйлгээ хэвийн явагдаж байна.

Статистикийн чиглэлээр: 2020 оны 4 дүгээр сарын нийгэм, эдийн засгийн танилцуулга гаргаж байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Хэвлэмэл байдлаар 45 хэрэглэгчид тарааж, цахимаар 150 хэрэглэгчид хүргэсэн.

Хагас жилийн мал тооллогын түүвэр судалгааны сургалтыг онлайнаар зохион байгуулж сумдын төрийн сангийн мэргэжилтнүүд болон тооллогын комиссын гишүүдийг хамруулсан.

Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр: Баянтал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 12426.1 мянган төгрөгийн зөрчил илрүүлэн 3461.0 мянган төгрөгийг холбогдох эздээр нөхөн төлүүлж орон нутгийн орлого болгох, 670.5 мянган төгрөгийг эздэд нь буцаан олгуулахаар, нийт 4131.5 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоосон.

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэвэр

| № | Төрөл | 2019.05.24 | | 2020.05.24 | | Шинээр тогтоолгосон |
|---|----------------------|------------|---------------------------|------------|---------------------------|---------------------|
| | | Хүний тоо | Тэтгэврийн дүн /мян, төг/ | Хүний тоо | Тэтгэврийн дүн /мян, төг/ | |
| 1 | Өндөр настан | 1689 | 3339183.4 | 1796 | 3765028.1 | 107 |
| 2 | Хөгжлийн бэрхшээлтэй | 313 | 340014.6 | 354 | 624200.7 | 41 |

| | | | | | | |
|---|------------------|-------------|------------------|-------------|------------------|------------|
| 3 | Тэжээгчээ алдсан | 126 | 180882.8 | 137 | 189307.9 | 11 |
| 4 | Үйлдвэрийн осол | 54 | 80901.0 | 27 | 76563.1 | -27 |
| | Нийт дүн | 2182 | 3940981.8 | 2314 | 4655099.8 | 132 |

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж

| № | Төрөл | 2019.05.24 | | 2020.05.24 | |
|---|-----------------|------------|------------------------------|------------|------------------------------|
| | | Хүний тоо | Тэтгэмжийн дүн /мян. төг/ | Хүний тоо | Тэтгэмжийн дүн /мян. төг/ |
| 1 | ХЧТА тэтгэмж | 444 | 56083.9 | 446 | 58723,3 |
| 2 | ЖБА тэтгэмж | 131 | 194279.6 | 154 | 253410,8 |
| 3 | Оршуулга | 27 | 27000,0 | 27 | 27000,0 |
| 4 | ҮОМШӨ-ХЧТА | 6 | 2494,5 | 2 | 3617,2 |
| 5 | Ажилгүйдэл | 86 | 182265,6 | 295 | 179119,3 |
| | Нийт дүн | 694 | 462123,6 | 924 | 521870,6 |

Сайн дурын даатгал:

| Сайн дурын даатгалын хамрагдалт | 2019.05.24 | 2020.05.24 |
|---------------------------------|------------|------------|
| Шинээр | 88 | 261 |
| Мөнгө тушаасан | 539 | 416 |
| Тушаасан мөнгөн дүн / мян төг/ | 118439,1 | 31071,6 |

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Архивын ажлын чиглэлээр: Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 5 хөмрөгийн 68 хадгаламжийн нэгжийн 522 заалт бүхий 4927 хүний нэр, 537 байгууллагын нэр, 1545 газар зүйн нэр, нийт 4496 хуудас баримтыг цахимжуулж, 98 хадгаламжийн нэгжийн 10595 хуудас баримтыг скайнердан оруулсан байна. Архивын баримтаас 17 иргэнд лавлагаа мэдээлэл олгох үйлчилгээ үзүүлсэн.

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан-4
- Иргэний үнэмлэх шинээр олгосон -56
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо- 36
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 4
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо -1
- Үрчлэлтийн бүртгэлийн тоо - 2
- Эцэг тогтоолтын бүртгэлийн тоо - 4
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 8

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 5
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 40
- Гэрээний бүртгэл - 32
- Барьцааны гэрээний бүртгэл -157
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга -6

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 4
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт -15

Архивын чиглэлээр:

- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 0198

- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 157-г олгож, нийт 355 иргэнд төрийн үйлчилгээг хүргэсэн.

Цагдаагийн хэлтэс нь: Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, хэв журмын эргүүлийн чиглэлийг гудамж талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор эргүүл, шалгалтын ажлыг тасралтгүй зохион байгуулж давхардсан тоогоор 114 алба хаагч 386 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, зөрчил гаргасан 111 иргэнийг эрх бүхий албан тушаалтны зүгээс 36,850,000 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 42 хүнийг эрүүлжүүлэх, баривчлах, саатуулах байранд хүргэн захиргааны журмаар түр саатуулсан.

Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, “Хүүхдийн хөгжлийн онцлог”, “Гэрийн дүрэм”, “Хүүхдийн аюулгүйн дүрэм”, “Хүүхдийг зодож шийтгэх нь хүмүүжлийн арга биш”, Хүүхдэдээ бахархан дуурайх аав ээж нь байя” гарын авлага, брошур, зөвлөмжийг иргэдэд хүргэсэн.

“Ачаа тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал” арга хэмжээний хүрээнд мотоцикльтой иргэдийн бүрэн бүтэн байдал, хамгаалах малгай, бичиг баримтыг шалган, зөрчилтэй явсан 38 иргэнийг 950 000 төгрөгөөр торгож, зөрчлийг засуулан арга хэмжээ авч ажилласан. Мөн мотоциклийн жолооч нарт зам тээврийн осол хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх зорилгоор сумдын багийн малчин 113 айл өрхөөр хамгаалах малгайн ач холбогдлын талаар яриа таниулга хийн, тэдэнд зөвлөмж хүргүүлээ.

Шүүхийн шинжилгээний алба: Хэргийн газрын үзлэгт 22 удаа оролцсоноос зам тээврийн ослын 7, хулгайлах гэмт хэрэг 4, хүний амь нас эрсэдсэн 5, бусад хэргийн газрын үзлэгт 6 удаа оролцож, хэргийн газраас гарын мөр 11, гутлын мөр 4, тээврийн хэрэгслийн мөр 9, бусад ул мөр, эд мөрийн баримт 40-ийг илрүүлэн бэхжүүлж, хэргийн материалд хавсаргасан. Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 835 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих анги: Тайлант хугацаанд шинээр ирсэн 18 хоригдлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд заагдсан хоригдлын эрх, үүрэг, Албан хаагчийн аюулгүйн тойрог, Хоригдлын хяналтын хуудас зэрэг сэдвүүдээр 2 удаагийн сургалтанд хамруулж, энгэрийн тэмдэг, хяналтын хуудсыг олгон сэтгэл зүйн болон Угийн бичиг хөтлөх сургалтанд хамруулсан.

Суллагдах хугацаа нь дөхсөн 45 хоригдлыг нийгэмшүүлэх зорилгоор 2 удаагийн сургалтад хамрууллаа. Мөн хоригдлын авьяас, ур чадварыг хөгжүүлэх, давуу талыг нээн илрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор шагайн харвааны дугуйланд 16, морин хуурын дугуйланд 4, даалингийн урлах дугуйланд 18, сагсан бөмбөгийн дугуйланд 18, гар бөмбөгийн дугуйланд 17, ширээний теннисний дугуйланд 21, монгол бичгийн дугуйланд 16, бичиг үсгийн сургалтад 3 хоригдол цагийн хуваарийн дагуу хичээллэж байна.

Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран хоригдлыг бичиг баримтжуулах буюу иргэний үнэмлэх шинээр болон дахин олгох, иргэний үнэмлэхний хугацаа сунгах зэрэг зөрчилтэй 4 хоригдлын иргэний үнэмлэхийг захиалж, 10 хоригдлыг бичиг баримтжуулахаар материалыг холбогдох байгууллагад хүргүүлсэн.

2020 оны 5 дугаар сард төлбөрийн 80 гүйцэтгэх баримт бичгээс 47 гүйцэтгэх баримт бичгийн 596249.7 мянган төгрөг, 4 хүүхдийн тэтгэлгийн баримт бичгийг бодитой биелүүлж гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 26.2 хувьтай байна.

Мэргэжлийн хяналтын газар нь:

Улсын онцгой комиссын шийдвэрийн хүрээнд шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор түр сургалтын төв, жолооны курс, саунд эрүүл ахуй халдвар хамгаалал, боловсрол соёлын хяналтын чиглэлээр улсын байцаагчийн зөвлөмж, үүрэг чиглэл өгч, биелэлтэд хяналт тавин ажилласан.

Ковид-19 цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, нөөцийн бэлэн байдлыг хангаж ажиллах талаар улсын байцаагчийн зөвлөмжийг эм хангамжийн 8 байгууллагад хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан худалдаа үйлчилгээний байгууллагуудад хүнсний чанар стандарт, эрүүл ахуйн хяналтын чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж байна. Шалгалтын явцад хаяг шошго зөрчилтэй, хадгалах хугацаа хэтэрсэн 3 нэр төрлийн 30ш 92500 төгрөгийн бүтээгдэхүүнийг аж ахуйн нэгжийн дотоод хяналтаар газар дээр нь устгаж, хүнсний аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, зөрчлийг арилгаж, хүүхдийн баярын бэлэг, түүний чанар аюулгүй байдалд хяналт хийж, хүнсний худалдаа үйлчилгээний 8 ажилтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Хүнсний чанар, стандарт, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч нар болон аж ахуй нэгж байгууллага, иргэний хүсэлтээр ирүүлсэн усны 15, хүнсний бүтээгдэхүүний 10, гурилан бүтээгдэхүүний 8, хоолны 10, кетчупны 2, ариун материалын 10, арчдасны 30, агаарын 7, нийт 94 сорьцод 325 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг хийж гүйцэтгэхэд эерэг сорьц 3 илэрсэн.

Онцгой байдлын газар нь: Монгол Улсын Шадар сайдын баталсан “Маскаа зүүцгээе” аяны хүрээнд иргэдэд “Ковид-19” халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлэгийг 21 удаагийн сурталчилгааны ажлыг томоохон худалдааны төв, гудамж, талбайд явж 10 газарт 6-10 удаагийн давтамжтай, нийт 1000 удаа нэвтрүүлэн, давхардсан тоогоор 126000 иргэнд хүргэн, амны хаалтаа зүүхийг уриалан ажиллаж, томоохон худалдааны төв, гудамжаар амны хаалтгүй явж буй иргэдэд 50 ширхэг амны хаалт тараан, хүүхэд багачуудыг олноор тоглоомын талбайд тоглохгүй байх, амны хаалтаа зүүж хэвших, амны хаалтаа зүүгээгүй иргэдийг зөрчлийн тухай хуулийн 5.13.1-д зааснаар торгох арга хэмжээг авах талаар яриа танилцуулга хийж, 2 нэр төрлийн 5000 ширхэг гарын авлага тараан ажилласан.

Гал түймрийн 2 удаагийн дуудлагаар гал унтраах зориулалтын үндсэн албаны болон туслах албаны автомашинтай давхардсан тоогоор 16 алба хаагч ажиллан шатлагыг зогсооход гал унтраах бодис 3 тн ус, 141 литр шатахуун зарцуулан, иргэдийн 17 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалж, 11 сая төгрөгийн хохирол учирсан.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: Элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэх зорилгоор онлайн цахим сорилго шалгалтыг 2 дахь удаагаа зохион байгууллаа. Тус шалгалтанд давхардсан тоогоор 577 сурагч хамрагдсан.

2019-2020 оны хичээлийн жилийн цэцэрлэгийн дэвшилт, төгсөлтийг салбарын мэдээллийн систем дээр хийсэн. Энэ хичээлийн жилд 976 хүүхэд анги дэвшиж, 720 хүүхэд төгссөн.

2019-2020 оны хичээлийн жилд суурь боловсролд 283, бүрэн дунд боловсрол эзэмших 207 нийт 490 гэрчилгээ үнэмлэхний захиалгыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яаманд хүргүүлсэн.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Өсвөр насны хүүхдүүдэд ирээдүйд эзэмших мэргэжлээ зөв сонгохтой холбоотой мэдээлэл өгөх, ахлах ангийн сурагчдыг эрсдлээс урьдчилан сэргийлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил сонголтод арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор 2020 оны 5 дугаар сарын 4-ний өдрөөс 6 дугаар сарын 04-ний өдрүүдэд “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аяныг цахимаар зохион байгуулж байна.

Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Хуулиа мэдье-Хариуцлагаа ухамсарлъя” хууль сурталчилах сарын аяныг 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөс 5 дугаар сарын 13-ны өдрүүдийн хооронд зохион байгуулсан. Аяны хүрээнд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийг цахимаар иргэдэд хүргэж, мэдээлэл, зөвлөгөө, зөвлөмж өгч байна.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг угтан “Миний гэр бүлийн аз жаргал” аяныг 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 6 дугаар сарын 1-ний өдрүүдэд зохион байгуулж байна. Аяны хүрээнд “Миний гэр бүлийн өглөөний дасгал”, “Үлгэрч аав, ээж”, “Гэр бүлээрээ Тик Ток хийцгээе”, “Угийн бичиг хөтөлдөг шилдэг гэр бүл”-ийг шалгаруулах уралдаануудыг цахимаар зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хүүхэд багачуудын хөгжлийг дэмжих, эцэг эхчүүдийн хүүхэддээ зарцуулах цагийг үр дүнтэй болгох зорилгоор Монгол ардын уламжлалт зүйр цэцэн үг, ертөнцийн гурав, монголын уран зохиолыг унших, аймгийн 9 гайхамшигийг судлан танин мэдэх иргэдэд түгээх, дэлхийн сонгодог зохиолтой танилцах, хүүхдийн бие даан хөгжих боломжийг дэмжих, сэтгэхүй хөгжүүлэх, танин мэдэхүйн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Хүүхэд бидний хөгжил-оролцоо” сарын аяныг 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс 5 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Тус уралдааныг 5 насны ангиллаар зохион байгуулж, сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүд болон ерөнхий боловсролын сургуулийн нийт 200 хүүхэд тус тэмцээнд цахимаар оролцож, нийт 50 гаруй хүүхдийг шагнаж урамшуулсан.

Соёл, урлагийн чиглэлээр: “Боржигин өв” музей нь соёлын өвийг сурталчлах зорилгоор иргэдэд цахим үйлчилгээ хүргэн ажиллаж байна. Тайлант хугацаанд 102 иргэн цахим үйлчилгээ авсан байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон төрийн байгууллагын албан хаагч нарт “VRBOX”-оор музейн явуулын соёлын үйлчилгээ үзүүлсэн. 2020 оны 5 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд Сүмбэр сумын хөдөөгийн 5,6-р багийн 76 малчинд гэрт нь очиж “VRBOX” -оор цахим музей үзүүлж, Чулуун өв соёл, Боржигин өв соёл гарын авлага, Боржигин өв соёл DVD тарааж соёлын үйлчилгээ үзүүлсэн.

Угийн бичиг хөтлөх анхан шатны сургалтыг цахимаар зохион байгуулж, нэгдсэн эмнэлгийн 27 ажилтан, албан хаагч, төмөр замын 10 байгууллагын 135 албан хаагч, аймгийн Засаг даргын тамгын газрын 54 албан хаагчийг хамруулсан.

Аймгийн номын сангаас Хүүхэд багачуудад Монгол ардын үлгэр “Ухаантай эр” “Алтан загасны үлгэр” “Залхуу муур” “Зэрлэг хун шувууд” “Бяцхан янзага” зэрэг үлгэрийг цахимаар хүргэж, 1220 уншигчид цахим хэлбэрээр номыг уншсан байна.

Биеийн тамир, спортын чиглэлээр: Монгол улсын Ерөнхийлөгчийн 53 дугаар зарлиг, Засгийн газрын 2019 оны 153 дугаар тогтоол “Төрийн биеийн тамир спортын талаар баримтлах бодлого”, Улсын Онцгой комиссын 2020 оны 13 дугаар хурлын тэмдэглэл, Аймгийн Засаг даргын А/35 дугаар захирамжийн хүрээнд 15 төрлийн цахим тэмцээнийг 2020 оны 5 дугаар сарын 10-31-ны өдрийг хүртэл зохион байгуулж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

| Үзүүлэлт | 2019 оны 05 сар | 2020 оны 05 сарын 20- ны байдлаар |
|---------------------------|--------------------|--------------------------------------|
| Төрсөн эх | 167 | 160 |
| Гэрийн төрөлт | 1 | 0 |
| Амьд төрсөн хүүхэд | 168 | 162 |
| Амьгүй төрөлт | 1 | 0 |
| Нас баралт | 24 | 26 |
| Эмнэлгийн нас баралт | 6 | 2 |
| Хоног болоогүй нас баралт | 2 | 0 |

| | | |
|-------------------------------------|--------|--------|
| 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл | 4 | 0 |
| 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл | 0 | 2 |
| Эмнэлгээс гарсан хүний тоо | 2 131 | 1 769 |
| Амбулаторийн үзлэг | 41 855 | 36 160 |
| Халдварт өвчин | 91 | 47 |

Эрүүл мэндийн газраас санаачлан “Энхийн шүүдэр” ХХК, “Говийн сондор” ХХК-тай хамтран “Дэмжье-түншлэе” төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү төслийн хүрээнд удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардагдах эмгэгүүд болох паркинсон, чихрийн болон чихрийн бус шижин, уналт таталт (Эпилепси), бамбай булчирхайн дутмагшил зэрэг оноштой, өдөр бүр тогтмол эм хэрэглэдэг 10 өвчтөнийг сонгон “Энхбилиг” эмнэлэгт хэвтүүлэн хордлого тайлах, шингэн нөхөх, уламжлалт бариа засал зэрэг нэмэлт эмчилгээнд үнэ төлбөргүйгээр хамруулахыг зорьсон. Одоогийн байдлаар 2 хүнийг хэвтүүлэн эмчилж байна. Төсөл хамтран хэрэгжүүлэгч “Энхийн шүүдэр” ХХК-аас 500 мянган төгрөгийн өртөг бүхий 8 нэр төрлийн дусал, шингэнийг хүлээн авч, эмчилгээнд хэрэглэж байна.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дурангийн мэс заслын эмч н.Санчин дурангаар цөсний чулуу авах хагалгааг 5 иргэнд, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн эмч н.Мэндсайхан чих хамар хоолойн хагалгааг 7 иргэнд үнэ төлбөргүй хийж эмч нарыг ажлын байран дээр сургаж дадлагажуулах ажлыг зохион байгууллаа.

Хөдөлмөр, халамжийн чиглэлээр: 2018, 2019 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөтөлбөрийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн эргэн төлөлтөд хяналт хийж, тайлант сард 12612.0 мянган төгрөг, өссөн дүнгээр 61 хүний 58840.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, хугацаа хэтэрсэн зээлдэгч байхгүй байна.

Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, дэлхий нийтэд тархаад буй корона вирусын цар тахлын үед хүүхдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэн гудамж талбай олон нийтийн газарт хяналт тавин халдварын үеийн сахилгыг мөрдүүлэх, хүүхэд бүрийн гэрээс сургууль хүртэл, сургуулаас гэр хүртэлх замыг хяналтад авч тэднийг эрүүл, аюулгүй зорчиход хүүхэд бүрийг эрсдлээс хамгаалахад “ХҮҮХЭД ХАМГААЛАГЧ” төслийг 2020 оны 5 дугаар сараас 12 дугаар сарыг дуустал хэрэгжүүлэхээр эхлүүлээ. Төсөлд Цагдаа болон боловсролын байгууллагаас тэтгэвэрт гарсан 2 ахмад түр ажлын байраар хангагдаж төсөл хэрэгжих хугацаандаа нийт 660 цаг үүрэг гүйцэтгэж, цалин урамшуулалд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 4620.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд нийтийг хамарсан ажил зохион байгуулж, түр ажлын байраар хангах арга хэмжээнд нутгийн захиргааны байгууллагуудаас төслийг хүлээн авч, гэрээ байгуулан хамтран ажилласан. Үүнд:

- Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГазар “Нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдлыг цэвэрлэх” төсөлд 22 хүн
- Сум дундын ойн анги “Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг арчлах, хамгаалах” төсөлд 60 хүн
- Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар “Нийтийн эзэмшлийн талбайн тохижилтын ажил” 10 хүн
- Баянтал сумын Засаг даргын Тамгын газар “Нийтийн эзэмшлийн талбайн тохижилтын” төсөлд 10 хүн
- Баянтал сумын Засаг даргын Тамгын газар “Бэлчээрийн оготно устгал” төсөлд 7 хүн
- Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар “Мэрэгчгүй Шивээговь” төсөлд 7 хүн
- Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар “Бэлчээрийн оготно устгал” төсөлд 31 хүн, нийт 147 иргэнийг нийтийг хамарсан түр ажлын байраар хангахаар гэрээ байгуулан, гэрээний хугацаагаар 58 иргэнийг түр ажлын байраар хангаж, цалингийн зардалд 5390,0 мянган төгрөг зарцуулаад байна.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Мал, аж ахуйн чиглэлээр: “Бэлчээр хамгаалах ажлыг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2019 оны 185 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Бэлчээрийн хортон мэрэгч, үлийн цагаан оготной тэмцэх ажлыг зохион байгуулах тухай” 2020 оны А/128 дугаар захирамжийн хүрээнд бэлчээрийн хортон мэрэгч, үлийн цагаан оготной тэмцэх ажлыг Баянтал суманд 10.0 мян.га, Сүмбэр суманд 40.0 мян.га, Шивээговь суманд 10.0 мян.га, нийт 60.0 мян.га бэлчээрийг хамруулан зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/127 дугаар захирамжийн дагуу мал сүрэгт үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг сумдын Засаг даргын Тамгын газар, Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжүүдтэй гэрээ байгуулан эхлүүлээд байна.

2020 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 15109 эх мал төллөж, 149760 төл бойжиж байна. Төллөлт 82.3 хувь, төл бойжилт 98.9 хувьтай байна. 1603 төл мал хоргодож, том малын зүй бус хоргодол 997 байна.

Арьс, ширний урамшууллын програм шинэчлэгдсэнтэй холбогдуулан 2019 онд 50.0 мян.ширхэг арьс, шир бэлтгэн үндэсний үйлдвэрт тушаасан 331 малчин, мал бүхий этгээдэд 163.3 сая төгрөгийн урамшуулал олгуулахаар цахим санд мэдээллийг оруулсан.

2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 1 га талбайд төмс, 1 га талбайд хүнсний ногоо тариалсан байна. Цаг агаарын нөхцлөөс шалтгаалан тариалалтын ажил удаашралтай явагдаж байна. Хүнсний нарийн ногооны үрсэлгээг 3 иргэн, модны суулгацыг 1 иргэн бэлтгэн, орон нутгийн иргэдэд нийлүүлж байна. Тариалалтын ажлыг 13 иргэн, 1 аж ахуйн нэгж эхлүүлж, техникийн үйлчилгээг 2 цэгээс үзүүлсэн бөгөөд 5 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 5.2 га талбайд хөрс боловсруулалтын ажил хийгдсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас олгож буй техник тоног төхөөрөмж, чацарганы суулгацын зээлийн талаарх мэдээллийг сумдын Хөдөө аж ахуйн тасгууд болон цахим хуудсуудаар дамжуулан иргэдэд хүргэж байна. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжих зориулалтаар ирүүлсэн 9 төрлийн 52 кг хүнсний ногооны үрийг татан авч, сумдын Хөдөө аж ахуйн тасгуудаар дамжуулан иргэдэд олгож байна.

Төмс, хүнсний ногоо жимс, жимсгэнэ тариалах хүсэлтэй 21 иргэнийг арга зүйн зөвлөгөөгөөр ханган, шинээр ногоо тариалах санаачилга гаргасан 2 иргэнийг Шивээгийн булгийн услалтын системийг түшиглэн хашаажуулсан талбайд тариалалт хийлгэхээр шийдвэрлэсэн.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох хүрээнд 2020 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс 5 дугаар сарын 19-ний өдрийг дуустал аж ахуйн нэгжүүдийн төсөл хүлээн авах ажлыг зохион байгуулж, нийт 3,3 тэр бум төгрөгийн 21 төсөл ирсэн бөгөөд журмын дагуу төслүүдийг программд бүртгэн хүлээн авч, бичиг баримтын иж бүрдлийг шалгах, судалгаа хийх ажил хийгдэж байна.

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2020 оны 05 дугаар сарын үнийн мэдээ

Зах зээлд худалдаалагдаж буй Үхрийн /ястай/ махны үнэ 500 төгрөгөөр, хонины мах /цул/ 500 төгрөгөөр, адууны мах /цул/ 500 төгрөгөөр, ямааны мах /цул/ 500 төгрөгөөр, төмс 250 төгрөгөөр зарим хүнсний ногооны үнэ өнгөрсөн сараас 50-250 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

| № | Бараа бүтээгдэхүүн | Дээд үнэ төг | Доод үнэ төг | Өссөн буурсан |
|---|--------------------|--------------|--------------|---------------|
|---|--------------------|--------------|--------------|---------------|

| | | | | | |
|----|---------------------|----------------------------|-------|-------|-------|
| 1 | Үхрийн мах | ястай | 10000 | 8500 | 10000 |
| | | цул | 12000 | 11000 | 12000 |
| 2 | Хонины мах | ястай | 8000 | 7000 | |
| | | цул | 10000 | 10000 | +500 |
| 3 | Адууны мах | ястай | 8500 | 7500 | |
| | | цул | 9000 | 9000 | +500 |
| 4 | Ямааны мах | ястай | 7000 | 6000 | |
| | | цул | 9000 | 9000 | +500 |
| 5 | Тахианы мах | гуя | 10500 | 10000 | |
| | | мөч | 9800 | 9000 | |
| 6 | Лууван | монгол | 2000 | 1200 | - |
| | | хятад | | | |
| 7 | Төмс | монгол | 1250 | 850 | +250 |
| | | хятад | | | |
| 8 | Байцаа | монгол | 1500 | 1200 | |
| | | хятад | | | - |
| 9 | Чинжүү | монгол | | | - |
| | | хятад | 6500 | 5500 | |
| 10 | Манжин | монгол | 3800 | 3200 | +50 |
| | | хятад | | | - |
| 11 | Сонгино бөөрөнхий | монгол | 3000 | 2500 | - |
| | | хятад | 1500 | 1400 | - |
| 12 | Улаан лооль | монгол | 6000 | 5500 | - |
| 13 | Өргөст хэмх | монгол | 8000 | 6500 | - |
| 14 | Элсэн чихэр | монгол | 2100 | 1600 | - |
| 15 | Будаа | цагаан будаа задгай кг | 2500 | 2200 | +100 |
| | | шар будаа слава кг | 3500 | 3000 | - |
| | | гурвалжин будаа кг | 3800 | 2200 | - |
| 16 | Сүү | задгай | 2500 | 2000 | - |
| | | сүү ХХК 0,5л | | | |
| | | сүү ХХК 1л | 3200 | 3050 | - |
| 17 | Тараг | задгай | 2200 | 2000 | - |
| | | сүү ХХК 1л цөцгийтэй тараг | 4800 | 3800 | - |
| 18 | Талх | Чойр талх | 1200 | 750 | - |
| 19 | Өндөг | ОХУ | 400 | 330 | - |
| | | Монгол | 400 | 300 | - |
| 20 | Алтан тарианы гурил | задгай дээд | 1520 | 1480 | +250 |
| | | задгай 1-р зэрэг | 1140 | 1100 | +20 |
| | | задгай 2-р зэрэг | 1000 | 950 | - |
| | | савласан д/дээд / | 2400 | 2300 | - |
| | | савласан дээд | 2200 | 2100 | - |
| | | савласан 1-р зэрэг | 1400 | 1300 | - |
| | | савласан 2-р зэрэг | 1500 | 1450 | |
| 21 | Ургамлын тос | oleyна | 5500 | 4800 | +50 |
| | | алтан | 3800 | 3600 | - |
| 22 | Гоймон | aleyка | 1800 | 1600 | - |
| | | а/тариа савхан | 1100 | 950 | - |

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр: Бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд мод бутны үзэсгэлэн худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулж, Улсын тусгай хамгаалалттай Чойрын богд ууланд 108 ширхэг, сухай нийтийн эзэмшлийн гудамж талбайд 58 ширхэг, нийт 166 суулгац тарилаа.

Авто зам дагуух ойн зурваст 29 аж ахуйн нэгж байгууллагын 300 гаруй албан хаагч 1441 ширхэг хайлаас, 370 ширхэг шар хуайс, 100 ширхэг улиас, 58 ширхэг сухай, 50 ширхэг агч, 30 ширхэг голт бор, нийт 2049 ширхэг мод, бут тарьсан.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Уст цэгийн цэвэрлэгээ”-ний ажлыг 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Умард говийн гүвээт, Халхын дундад талын сав газрын захиргаатай хамтран зохион байгууллаа. Цэвэрлэгээгээр Уулзварын гол, Өехий булаг, Хүрийн ногоо, Цоорхойн рашаан орчмын хог хаягдлыг түүж цэвэрлэн, Цоорхойн рашаанд тарьсан моднуудыг тогоолж хаврын цэнэг усалгааг хийж, 4 тонн хог хаягдлыг цэвэрлэлээ.

Аймгийн “Агаар, орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр”-ийн хүрээнд босоо тэнхлэгийн авто зам дагуух барилгын болон хур хаягдалтай талбайг цэвэрлэх ажлыг “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-тай 2 га газрыг цэвэрлүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.

Бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд Сүмбэр сумын Засаг даргын 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/60 дугаартай захирамжаар сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төр, хувийн хэвшлийн ААН, байгууллагуудын орчны болон нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээг хийх хуваарийг батлан, 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөн ажиллаж байна.

Тээвэр, авто замын талаар: Тээврийн хэрэгслийн техникийн үзлэг оношилгоонд 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар 733 тээврийн хэрэгсэл хамрагдсан бөгөөд өссөн дүнгээр 2299 тээврийн хэрэгсэл хамрагдсан байна.

Тайлант хугацаанд хот хооронд 480 иргэн зорчиж, 42 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийгдэн, ачаа тээвэрлэлтийн 100 замын хуудас олгосон байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны А/73 дугаар тушаалаар батлагдсан “Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх” ажлын хүрээнд Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдад ажлын хэсэг байгуулагдан ажилласан.

Шивээговь суманд 2020 онд сумын орон нутгийн хөгжлийн сангийн 7 сая төгрөгөөр гэр хорооллын айл өрхийн гудамж, хашааны дугаарыг бүрэн хаягжуулж ажилласан. Үүнд: хашааны тэмдэг 247ш, гудамжны тэмдэг 38 ш, өргөн чөлөөний тэмдэг 2 ширхэгийг тус тус хийлгэж хаягжуулаад байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онд дамжин хэрэгжиж байгаа 100 ортой Нэгдсэн эмнэлгийн барилгын ажил 60 хувьтай, Сүмбэр сумын 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралтын ажил 55 хувьтай, Сүмбэр сумын 150 хүүхдийн суудалтай цэцэрлэгийн барилга угсралтын ажил 35 хувьтай, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилга угсралтын ажил 35 хувьтай, Сүмбэр сум 2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж тавих ажил 59 хувьтай, Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгын их засварын ажил 100 хувь хийгдсэн, Усан спорт сургалтын төвийн барилга угсралтын ажил 95 хувьтай, Чойрын хийдийн гол Дуганы барилга 40 хувьтай тус тус хийгдэж байна. Мөн Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэж буй Сүмбэр сумын 150 хүүхдийн суудалтай цэцэрлэгийн барилга угсралтын ажил 60 хувьтай хийгдэж байгаа бөгөөд Япон улсын Засгийн газрын “Өвсний үндэс” буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хөрөнгөөр хийгдэж буй Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн их засварын ажил 10 хувьтай тус тус хийгдэж байна.

Худалдан авах ажиллагааны талаар: Улсын төсвийн хөрөнгөөр 8 ажил хийгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсанаас 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 7 ажлын тендер шалгаруулалтыг зарлаж, 5 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан гэрээ байгуулсан, 1 ажлыг зарлаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сан, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 16 ажил хийгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсанаас 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 14 ажлын тендер шалгаруулалтыг зарлаж, 2 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хугацаа болоогүй, 12 ажлын гэрээ байгуулсан байна.

Авто замын сан, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсанаар 5 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар 5 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан байгуулж, ажлыг гүйцэтгүүлж байна.

Зарлагдсан тендерийн урилгуудыг “Монголын үнэн” сонин, www.tender.gov.mn govisumber.gov.mm сайтуудад тухай бүр нийтэлж, тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд оруулан ажиллаж байна.

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

Баянтал сум: Сумын Соёлын төвийн номын сангийн фондыг Орон нутгийн хөгжлийн сангийн 2 594 000 төгрөгөөр шинэ ном хэвлэлээр баяжуулж, нийт 122 нэрийн 264 номыг хүлээн авч техник ажиллагааг хийж, ном нэг бүрийн шинэ мэдээг гарган иргэдэд цахимаар хүргэж байна.

Аймгийн Мал эмнэлгийн газартай хамтарч шүлхий өвчний байгалийн халдвар илрүүлэх шинжилгээнд 1, 2 дугаар багийн 15 малчин өрхийн 225 толгой малаас цусны дээжийг цуглуулж холбогдох газар хүргүүлэн ажилласан.

Сумын төвийн нийтийн эзэмшлийн талбай, орон сууцны байруудын орц, 2 цайны газар, дэлгүүрүү зэрэг нийт 5000 м² талбайд ариутгал халдваргүйтгэлийг Мал эмнэлэгийн тасагтай хамтран хийж гүйцэтгэсэн.

Шивээговь сум: 2020 оны 5 дугаар сарын 2, 3-ны өдрүүдэд тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг зохион байгуулж, нийт 126 авто машин үзлэгт хамрагдсан байна.

Сумын Засаг даргын 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн А/79 дүгээр захирамжаар “Сумын гамшгийн эрсдлийн судалгааг гаргах” ажлын хэсгийг байгуулан 5 дугаар сарын 22-ны өдөр аймгийн Онцгой байдлын газартай хамтран ажлын хэсгийн 20 гишүүнд сургалт зохион байгуулж, аргачлалын дагуу сумын гамшгийн эрсдлийн тойм судалгааг хийж, гамшгийн эрсдлийг бууруулах төлөвлөгөөг гаргасан.

Сумын Хамтарсан багаас COVID-19 вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоож, хөл хорио тогтоосонтой холбоотойгоор ТВ хичээлд хамрагдахгүй байгаа хүүхдүүдийн гэрээр ангийн багшийн хамт айлчилж, шалтгаан нөхцөлийг тодруулсан. Нийт 15 сурагчийн нөхцөл байдлыг судалж, үүнээс санхүүгийн боломж буюу амьдралын боломжгүй 4 сурагч, эцэг эхийн анхаарал халамж сул 5 сурагч, гэртээ цоожлогдоод үлддэг 2 өрхийн 9 хүүхдийн нөхцөл байдалтай танилцсан. Хамтарсан багаас эцэг эхийн халамж анхаарлыг нэмэгдүүлэх талаар зөвлөгөөг тухай бүрт өгч, амьдралын боломжгүй сурагчдад хичээлийн хоцрогдолыг арилгах даалгаварыг тусгайлан бэлтгэж сурагчдад хүргүүлэх үүргийг ангийн багш нарт өгснөөр хичээлд хамрагдалт хэвийн үргэлжилж байна.

Сумын Засаг даргын “Нийтийн их цэвэрлэгээ, ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа зохион байгуулах” тухай захирамжийн дагуу бүх нийтийн их цэвэрлэгээг 5 дугаар сарын 8, 19-ний өдрүүдэд зохион байгуулж сумын төвийн ногоон байгууламжийн хашааг засах, модны нүхийг тогоолох, хог хаягдлыг түүж цэвэрлэх ажлыг 18 аж ахуй нэгж албан байгууллагын 74 ажилтан албан хаагч хамрагдаж, нийт 4 га талбайн 2,8 тн хог хаягдлыг төв хогийн цэгт зөөж тээвэрлэсэн. Мөн сумын төв хогийн цэгийн ойр орчмын хог хаягдлыг түрж тэгшлүүлсэн.

2020 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаатай хамтран Шивээговь сумын 69 худаг, 8 булаг шанд уст цэгийн байршил солбилцолыг баталгаажуулсан.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн зохион байгуулж өнөөдрийн байдлаар вакцинд 38 өрхийн 28078 толгой мал хамрагдаж тарилга 52.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг сумын 725 өрхөөс цаасаар, 83 өрхөөс цахимаар хүлээн авч, санал асуулгад нийт өрхийн 76 хувь нь хамрагдаад байна.

Сүмбэр сум: Сумын хэмжээнд нийтийн эзэмшлийн гудамж талбайд нэгдсэн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг аймгийн Онцгой байдлын газар болон Мал эмнэлгийн газартай хамтран зохион байгуулж 28 цэгт 101138 м² талбайд ариутгалын ажил хийсэн.

Уулзварын гол, Хүрий ногоо, Асгана, Өехий булаг, Цоорхойн рашааны орчмын хог хаягдлыг цэвэрлэн 4 тонн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлээ.

“Нийтийн эзэмшлийн гудамж талбайд цэвэрлэгээ хийх” тухай сумын Засаг даргын захирамжийн дагуу 05 дугаар сарын ээлжит цэвэрлэгээг зохион байгуулсан. Цэвэрлэгээнд нийт 21 байгууллага цэвэрлэгээнд гарсан бөгөөд 15 га газрыг цэвэрлэж, 7.1 тонн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн.